


Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн
даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ны 1/4 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Албан тушаалын нэршилд өөрчлөлт орсон
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

..... аймгийн Нийгмийн даатгалын
хэлтэс

Санхүү бүртгэлийн тасаг

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Сан хариуцсан мэргэжилтэн

ТҮ-7

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

..... аймаг,

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөг хангах, сангийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх, тайлан мэдээ гаргах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;

2.Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг хангах, сангийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх, тайлан мэдээ гаргах;

3.Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сангийн орлого, зарлагын төсвийн сарын мэдээг иж бүрэн гаргаж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, хугацаанд нь хүргүүлэх;	Холбогдох журам зааврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	2.Сангийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг тооцож, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах санал гаргах;	Сангийн төсвийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.Сангийн сарын мэдээ, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, хүргүүлэх;	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.	Г
	4.Шилэн дансанд оруулах мэдээллийг хугацаанд нь оруулах;	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Г
	5.Сангийн бүртгэл хөтлөх, программ хангамжийг боловсронгуй болгох санал боловсруулах.	Сангийн бүртгэл сайжирсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Сангийн орлого хуримтлуулдаг болон сангийн харилцах данс бүрээр орлогын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг хөтлөж, мэдээллийн цахим санд тухай бүр бүртгэх;	Сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.	Г
	2.Төрийн сан, арилжааны банкны хуулгаар анхан шатны баримтын бүрдэл дутуу, гүйлгээний утга тодорхойгүй орлогыг тухай бүр тодруулж, залруулах, холбогдох баримтыг бүрдүүлэн өглөг авлага	Холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байна.	Г

үүсгэхгүй байх, өмнөх хугацаанд үүссэн тооцооны өглөг авлагыг барагдуулах;		
3.Төвлөрсөн харилцах дансанд хуримтлагдсан орлогыг сангийн ногдуулалтанд үндэслэн тогтоосон хугацаанд хуваарилах тооцоо гаргаж, сан тус бүрийн харилцах дансыг холбогдох журмын хүрээнд үлдэгдэлтэй байлгах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
4.Сангийн төлөвлөгөөний сарын хуваарийн дагуу сумдаас сангийн орлогыг төвлөрүүлэх, төв сангаас санхүүжилт авч, сар бүр тооцоо нийлэх;	Сангийн төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна.	Г
5.Арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу төвлөрсөн болон сангийн харилцах дансны өдөр тутмын хүүгийн орлогын тооцоог хийн харилцах дансны хүүгийн тооцоонд хяналт тавьж, улирал бүр харилцагч банкаар баталгаажуулах;	Гэрээний заалт хангагдсан байна.	Г
6.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу хүлээн авах орлогыг хугацаанд нь авч, тооцооны өглөг авлага үүсгэхгүй байх, хоорондын тооцоог улирал бүр актаар баталгаажуулах;	Гэрээний заалт хангагдсан байна.	Г
7.Ажил олгогч, даатгуулагчийн төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, Улсын байцаагчийн актаар төлсөн шимтгэл, алданги, торгуулийн дүнг хариуцсан албан тушаалтантай тогтоосон хугацаанд тулган хянан баталгаажуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
8.Сангийн орлого хуримтлуулдаг болон сангийн харилцах данс бүрээр зарлагын гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлийг хөтлөж, мэдээллийн цахим санд тухай бүр бүртгэх;	Сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.	Г
9.Сангийн харилцах дансдаас шилжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, шимтгэлийг төсвийн сарын хуваарь, холбогдох	Төсвийн тухай хуулийг мөрдсөн байна.	Г

	баримтын бүрдэл, зөвшөөрлийг үндэслэн төлбөрийн хүсэлт, даалгаврыг бичиж, баталгаажуулан Төрийн сан, арилжааны банкинд зарлагын гүйлгээ хийлгэх;		
	10.Сангийн төлөвлөгөөний сарын хуваарийн дагуу сумдад олгох санхүүжилт, төв сан болон эрүүл мэндийн даатгалын харилцах дансны төвлөрүүлэлтийг хийж, сар бүр тооцоо нийлэх;	Сангийн төлөвлөгөөний биелэлт хангагдсан, эрүүл мэндийн даатгалын харилцах дансны орлогыг бүрэн шилжүүлсэн байна.	Г
	11.Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, шимтгэл, Улсын байцаагчийн актаар олгосон дүнг хариуцсан албан тушаалтантай тогтоосон хугацаанд тулган хянан баталгаажуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х
	12.Харилцах дансдын үлдэгдлийг тогтоосон хугацаанд баталгаажуулах;	Төрийн сан, арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдлийг үнэн зөв баталгаажуулсан байна.	Г
	13.Шимтгэл, тэтгэвэр, тэтгэмжийн тайланг тогтоосон хугацаанд нь хянаж;	Шимтгэл, тэтгэвэр, тэтгэмжийн тайланг тогтоосон хугацаанд нь хянаж, баталгаажуулсан байна.	Г
	14.Арилжааны банкууд болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний биелэлтийг гаргах, холбогдох санал боловсруулах;	Гэрээ хугацаандаа дүгнэгдсэн байна.	Г
	15.Мэргэжлийн болон хөндлөнгийн хяналтын байгууллагын шалгалтанд хамрагдах, Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлэх арга хэмжээ авах.	Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	Г
3 дугаар	1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх;	Албан хаагчийг эзгүй байгаа үед орлон гүйцэтгэн ажилласан байна.	Г
	2.Өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу өгөх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г
	3.Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад	Аливаа мэдээллийн нууцыг бусдад	Г

зорилтын хүрээнд	задруулахгүй ажиллах үүрэг хүлээх;	задруулахгүй ажилласан байна.	
	4.Гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж байх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.	Г
	5.Архивын материалыг цаг тухайд хүлээлгэж өгөх;	Цаг тухай бүр хүлээлгэн өгсөн байна.	Г
	6.Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг дагаж мөрдөж ажиллах;	Албан хэрэг хөтлөлт, архивын баримт холбогдох стандарт, зааварт нийцүүлэн ажилласан байна.	Г
	7.Ашиг сонирхлын зөрчлөөс өөрийгөө урьдчилан сэргийлж ажиллах;	Ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажилласан байна.	Г
	8.“Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч/ажилтан/-ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;	Журмыг хэрэгжүүлэн мөрдлөг болгон ажилласан байна.	Г
	9.Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.	Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - Нягтлан бодох бүртгэл /041101/; - Санхүү /041201/; - Даатгал /041201/; - Эдийн засаг /031101/. 	
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Нийгмийн даатгалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - нийгмийн даатгалын салбарын чиглэлээр мэдээлэл цуглуулах, мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - бодлогын судалгааны чанарын болон тоон аргыг ашиглан дүн шинжилгээ хийх; - нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хариуцан гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;

	<ul style="list-style-type: none"> - нийгмийн даатгалын салбарын асуудлын хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - нийгмийн даатгалын салбарын асуудлаар судалгаа хийж дүнг хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зарчимч, тууштай байх; - ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.
Бусад	<ul style="list-style-type: none"> - байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөж, ажиллах; - чанарын менежментийн тогтолцоо, стандартчилалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Санхүү бүртгэлийн тасгийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газар;
2. Аймгийн Засаг даргын тамгын газар;
3. Төрийн байгууллага, албан тушаалтан;
4. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага;
5. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН <i>Мундур</i> Д.ИДЭРЖАВХЛАН 20..... оны дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо..... <i>2023. 03. 27</i> Дугаар..... <i>А/39</i>
VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН	
<u>Байгууллагын нэр:</u> <i>Орхон</i> АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС Шийдвэрийн огноо..... <i>2023. 03. 31</i> Дугаар..... <i>А/11</i> (тамга/тэмдэг) ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ..... <i>Д.НАРМАНДАХ</i> <i>23</i> оны <i>03</i> дугаар сарын <i>31</i> -ны өдөр	